



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022.01.03

№ *АТЭГЭ*

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэнэ)-г нэг талаас "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" Улсын Төсөвт Үйлдвэрийн Газрын Хангамж үйлчилгээний албаны дарга Э.Энхгэрэл (цаашид "Захиалагч" гэнэ), нөгөө талаас "Виолета" ХХК-ний менежер Ч.Мөнхөө (цаашид "Ажил гүйцэтгэгч" гэнэ) (цаашид хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

1.Нийтлэг заалт

1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу хавсралт №1-д заагдсан ажлын байранд ариутгалыг чанрын өндөр түвшинд гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

2.Гэрээний хугацаа

2.1 Энэхүү Гэрээ нь 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хуанлийн 2 хоногийн хугацаатай байна.
2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3.Ажил үйлчилгээний төлбөр

3.1 Гэрээний дагуу ажил гүйцэтгэлийн хөлс 17 400 000 /арван долоон сая дөрвөн зуун мянга/ төгрөг төгрөг байна.
3.1.1 Захиалагч тал энэхүү гэрээ баталгаажсан өдөр ажлын хөлсийг гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн ХХБ банкны 42724335 тоот дансанд шилжүүлнэ.

4.Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
4.2 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

- 4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 4.4 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойш аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 4.5 Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.
- 4.6 Захиалагч нь баталгаат хугацааны дотор ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд тухайн доголдолыг арилгуулахаар Ажил гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 5.3 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.4 Дараахь тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:
- Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
 - Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
 - Ажил гүйцэтгэгч нь өөрийн инженер техникийн ажилчдын ХАБЭА-г бүрэн хариуцаж ажиллана
- 5.5 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.6 Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.
- 5.7 Ажлын үр дүн доголдолыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.
- 5.8 Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасаны дагуу шаардах эрхтэй.
- 5.9 Ажил үйлчилгээний даалгаварын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч талыг төлөөлж:


Хангамж, үйлчилгээний албаны дарга

 /Э.Энхгэрэл/

Хаяг: БГДүүрэг 17-р хороо
Утас: 75112020

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

"Виолета" ХХК-ий менежер

 /М.Мөнхөө/

Хаяг:
Утас: 99997982, 72116060



тоот гэрээний хавсралт №1


"Виолета" ХХК-ий ариутгал хийх салбарын жагсаалт

№	Салбарын нэр	Талбайн хэмжээ м2	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Захиргааны байр	775 м2	2 000	1 550 000
2	ТТС	360 м2	2 000	720 000
3	РНТС	7450 м2	2 000	14 900 000
4	ХШРА	115 м2	2 000	230 000
	Бүгд	8 700 м2		17 400 000

Хянасан: 

Э.Энхгэрэл
/Хангамж үйлчилгээний албаны дарга/



Ч.Мөнхөө 
/Виолета ХХК-ийн менежер/